



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2022 оны 05 сарын 19 өдөр

Дугаар 7/260

Арвайхээр

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Монголын Улаан загалмай нийгэмлэгийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5, Засгийн газрын 2016 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн “Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 234 дүгээр тогтоол, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны 08 дугаар сарын 29-ний “Хөтөлбөр батлах тухай” 56 дугаар тогтоол, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн “Өвөрхангай аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” 03/03 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтын 3.5.2.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хүмүүнлэгийн чиглэлээрх төрийн зарим чиг үүргийг аймгийн Улаан загалмай хороогоор гүйцэтгүүлэхэд 15,000,000 (арван таван сая) төгрөгийг зарцуулсугай.

2.Аймгийн Улаан загалмайн хороотой 2022 онд хамтран ажиллах гэрээг байгуулан, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ц.Ганболд)-д үүрэг болгосугай.

3.Дээрх 15,000,000 (арван таван сая) төгрөгийг аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Ц.Идэрсайхан)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

6222 11 0541